



**GRATA**  
INTERNATIONAL

**ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН МЭДЭЭЛЛИЙГ БҮРТГҮҮЛЭХ НЬ**

**GRATA International Mongolia**

[www.gratanet.com](http://www.gratanet.com)

## ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН МЭДЭЭЛЛИЙГ БҮРТГҮҮЛЭХ

### 1. Ерөнхий ойлголт

Олон Улсын Санхүүгийн Гэмт Хэрэгтэй Тэмцэх Байгууллага /ФАТФ/-аас 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Монгол Улсыг терроризмыг санхүүжүүлэх, мөнгө угаах явдлыг дэмжих таатай орон гэж үзэж хяналтын буюу “саарал жагсаалт”-д оруулснаа мэдэгдсэн.

ФАТФ –ын Зөвлөмжийн 24 болон 25 дугаар зүйл нь хуулийн этгээдийн ил тод байдал болон эцсийн өмчлөгчтэй холбоотой арга хэмжээ авахад чиглэдэг бөгөөд ФАТФ нь Монголын Харилцан үнэлгээний тайландаа эцсийн өмчлөгчтэй холбоотой дараах үнэлгээг хийсэн:

- Монгол Улс нь тус улсад байгуулагдсан төрөл бүрийн хуулийн этгээдтэй холбоотой эрсдэлүүдийг үнэлдэггүй бөгөөд Зөвлөмжийн 24 дүгээр зүйлийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүйн төлөө авах аливаа хориг арга хэмжээг тогтоогүй байна.
- Монгол Улс нь эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл эсхүл үндсэн хөрөнгийн хүсэлтэд хариу өгөх туслалцааны чанарыг хянах механизм байхгүй байна хэмээн үнэлсэн.

### 2. Хууль тогтоомж

ФАТФ –аас өгсөн үүрэг, даалгаврын хүрээнд Монгол Улс эцсийн өмчлөгчтэй мэдээллийг үнэн зөв бүртгүүлэхтэй холбогдуулан Улсын Их Хурлаас Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулсан.

Татварын ерөнхий хуулийг хэрэгжилтийг хангах журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн дагуу 2020 оны 1 сарын 1-ний өдрөөс өмнө хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн этгээд нь тухайн хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг 2021 оны 1 сарын 1-ний өдөрт багтаан хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлнэ

### GRATA International Mongolia

Дэлгэрэнгүй мэдээлэл  
авах эсвэл асуулт  
байвал ГРАТА  
Интернэшнл хуулийн  
фирмийн Партнер  
В.Болормаагийн  
bvoldoya@gratanet.com  
болон Хуульч  
Б.Янжмаагийн  
ybumtsend@gratanet.co  
m хаягаар эсвэл 976  
70155031 утсаар холбоо  
барина уу.

хэмээн заасан.

Харин Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 болон 10 дугаар зүйлд хуулийн этгээдүүд хуулийн этгээдийн хувийн хэргийг цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэн улсын бүртгэлийн мэдээллийн санд хөтлөх бөгөөд хуулийн этгээдийн хувийн хэрэгт хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон түүний хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээллийг тусгана. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээлэлд өөрчлөлт оруулах тохиолдолд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ.

### **3. Эцсийн өмчлөгч**

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн 3.1.6-д заасны дагуу Эцсийн өмчлөгч гэдэгт:

- Харилцагч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хувь хүн;
- Харилцагч нь хувь хүн бол тухайн хүний үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл тухайн хүнээр өөрийн үйлдлийг төлөөлүүлэн хийлгэж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүн;
- Хөрөнгийг удирдах хэлцлийн хувьд тухайн хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцлийн үндсэн дээр үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг ойлгоно.

УБЕГ-ын даргын 2020 оны А/1258 дугаар тушаалаар 2020 оны 8 дугаар сарын 17-нд батлагдсан Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд хөтлөх журамд хөрөнгийн дийлэнх хэсгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тухайн компанийн нийт хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хувьцаа, хуулийн этгээдийн хөрөнгийн 33% түүнээс дээш хувь байна хэмээн тайлбарласан.

Хэрэв хуулийн этгээд нь эцсийн өмчлөгчийг бүртгүүлэх үүргээ биелүүлээгүй эсхүл үнэн зөв мэдүүлээгүй тохиолдолд Зөрчлийн хуулийн 15.23-д заасны дагуу 500,000

төгрөг (ойролцоогоор 175.2 ам доллар) - өөр торгуулна. Эцсийн өмчлөгчийг тогтоох талаар хуульд заасан зохицуулалтыг зөрчсөн бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

#### **4. Дүгнэлт**

Монгол Улс саарал жагсаалтнаас гарахын тулд ФАТФ – ийн зөвлөмжийг хэрэгжүүлэх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор эрх зүйн томоохон шинэчлэлийг хийж байгаа бөгөөд эдгээр сайжруулалтын нэг нь эцсийн өмчлөгчийн мэдээллийг үнэнээр нь мэдүүлэх юм.

2020 оны 01 сарын 01-ний өдрөөс өмнө байгуулагдсан хуулийн этгээд нь эцсийн өмчлөгчийн мэдээллээ Улсын бүртгэлийн газарт үнэн зөвөөр бүртгүүлэх үүрэгтэй бөгөөд бүртгүүлэх үүргээ биелүүлээгүй эсхүл үнэн зөвөөр бүртгүүлээгүй тохиолдолд Зөрчлийн хуулиар хариуцлага хүлээнэ.

*Дэлхийн 20 улсад салбартай олон улсын хуулийн фирм ГРАТА Интернэшнлийн Монгол дах оффис болох Өмгөөллийн “Абсолют Адвокатс” ХХН энэхүү хууль зүйн мэдээллийг бэлтгэсэн. Энэхүү хуулийн зүйн мэдээлэл нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд тодорхой асуудалд нарийвчлан дүн шинжилгээ хийгээгүй болно. Энэхүү хууль зүйн мэдээллийг уншигч нь ямар нэгэн үйлдэл хийхээсээ өмнө өөрсдийн нөхцөл байдалд тохирсон мэргэжлийн зөвлөгөө авах хэрэгтэй. Энэхүү хууль зүйн мэдээллийг ашигласны улмаас үүссэн аливаа үр дагавар, хохирлыг бид хариуцахгүй.*